



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын Ерөнхий прокурор, харьяа прокурорын газруудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 254,832,982.13 (хоёр зуун тавин дөрвөн сая найман зуун гучин хоёр мянга есөн зуун наян хоёр төгрөг арван гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 249,584,983.40 /хоёр зуун дөчин есөн сая таван зуун наян дөрвөн мянга есөн зуун наян гурван төгрөг дөчин мөнгө/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 10 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Улсын Ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Цогтбаатар болон харьяа газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, бүртгэх;

2.4. Худалдсан автомашиныг улсын бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2021 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13201100

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн
44 дугаар тогтоолын хавсралт

Улсын Ерөнхий прокурор, харьяа прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашин

Д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Гүйлт (км)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Эзэмшигч байгууллагын нэр	Худалдах доод үнэ /төгрөг/
1	Ниссан кашкей, суудлын автомашин 08-31 УБҮ, Арлын дугаар: SJNFBNJ10Z2380541	2011/2011	74,126	46,900,000.00	46,900,000.00	-	Улсын Ерөнхий прокурорын газар	3,000,000.00
2	Ниссан кашкей суудлын автомашин, улсын дугаар 29-17 УНТ, Арлын дугаар: SJNFBNJ10Z2376123	2011/2011	51,798	46,900,000.00	46,900,000.00	-	Улсын Ерөнхий прокурорын газар	1,500,000.00
3	Микро автобус, Жимби хайс, улсын дугаар 98-41 УБН, Арлын дугаар: LSYHDAAA77K061008	2008/2011	41,086	18,117,200.00	18,117,200.00		Улсын Ерөнхий прокурорын газар	800,000.00
4	Ниссан кашкей суудлын автомашин, улсын дугаар 30-19 УНТ, Арлын дугаар: SJNFBNJ10Z2377161	2011/2011	61,786	46,900,000.00	46,900,000.00		Баянгол дүүргийн Прокурорын газар	1,500,000.00
5	Ниссан кашкей суудлын автомашин, улсын дугаар 08-36 УБҮ, Арлын дугаар: SJNFBNJ10Z2370976	2011/2011	51,798	46,900,000.00	46,900,000.00		Налайх, Багахангай дүүргийн Прокурорын газар	3,000,000.00
6	Ланд крузер -80 суудлын автомашин, улсын дугаар 64-71 ӨМҮ, Арлын дугаар: HDJ810050799	1995/2004	438,864	10,371,785.46	10,371,785.46		Өмнөговь Ханбогд сум дахь Сум дундын Прокурорын газар	1,000,000.00
7	Тоёота чейзер суудлын автомашин, улсын дугаар 0009 ХЭА Арлын дугаар: CX100-0121953	2001/2010	146,675	10,000,000.00	10,000,000.00		Хэнтий аймгийн Прокурорын газар	800,000.00
8	Хьюндай Соната-6, суудлын автомашин, улсын дугаар 8810 БУЛ, Арлын дугаар: KMHEU41MP7A322013	2007/2012	309,916	5,500,000.00	5,500,000.00		Булган аймгийн Прокурорын газар	800,000.00

9	Ниссан кашкей суудлын автомашин, улсын дугаар 06-61 УБ, Арлын дугаар: SJNFBNU10Z2375199	2011/2011	111,258	3,243,996.67	2,162,664.48		Сэлэнгэ аймаг Сайхан сум дахь Сум дундын Прокурорын газар	1,000,000.00
10	Хайлюкс, суудлын автомашин , улсын дугаар 00-68 ӨВР арлын дугаар:RZN2150007435	2003/2016	176,113	20,000,000.00	15,833,333.46	4,166,666.54	Өвөрхангай аймаг Хархорин сум дахь Сум дундын Прокурорын газар	5,000,000.00
	Нийт дүн			254,832,982.13	249,584,983.40	4,166,666.54		18,400,000.00
				/хоёр зуун тавин дөрвөн сая найман зуун гучин хоёр мянга есөн зуун наян хоёр төгрөг арван гурван мөнгө/	/хоёр зуун дөчин есөн сая таван зуун наян дөрвөн мянга есөн зуун наян гурван төгрөг дөчин мөнгө/	/дөрвөн сая нэг зуун жаран зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг тавин дөрвөн мөнгө/		/арван найман сая дөрвөн зуун мянга/